



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/100

Цагаан-Уул сум

Г Хяналт тавих комисс томилох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа Ухаалаг худгийн ажилд хяналт тавих комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ахлагч: О.Дашбямба (Галт дулаан ХХК-ны механикч)

Гишүүд: М.Бямбасүрэн (Нутаг бэлчээр хариуцсан мэргэжилтэн)

Б.Ичинхорлоо (Хууль эрх зүйн мэргэжилтэн)


Ч.Батчимэг (Галт дулаан ХХК-ны нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: Н.Пүрэвжаргал (Иргэдийн төлөөлөгчдийн хурлын мэргэжилтэн)

2. Ажлын даалгавар, зураг төсвийн дагуу явцын хяналтыг чанартай зохион байгуулж ажиллахыг хяналт тавих комисс (О.Дашбямба)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-т даалгасугай

ОРЛОГЧ ДАРГА



У.АВАРЗЭД